



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/232-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас:7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2022 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5-6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7-8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9-10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
2.7 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Ахмадын сан/.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15-16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16-17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17-18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18-19
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	20-21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.24 № СЭА-2022/232-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-г

МАНДАЛ СУМ ДАХЬ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ХЭЛТЭС-413 ДУГААР НЭЭЛТТЭЙ,
ХААЛТТАЙ ХОРИХ АНГИЙН
ДАРГА, ХУРАНДАА
А. БУЯНБААТАР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	264,025,904.52	282,147,022.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,652,714.80	16,941,967.97
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	14,652,714.80	16,941,967.97
3121	Төгрөг	14,652,714.80	16,941,967.97
31211	Төрийн сангийн харилцах	14,652,714.80	16,941,967.97
33	АВЛАГА	7,143,450.00	7,000,000.00
335	Бусад авлага	7,143,450.00	7,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	7,143,450.00	7,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	242,229,739.72	258,205,054.22
351	Түүхий эд материал	33,578,099.23	42,603,516.13
35110	Тусгай зориулалттай материал	31,385,205.20	40,242,060.20
35130	Эм боох материал	2,192,894.03	2,361,455.93
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	32,471,246.12	12,945,504.44
35300	Бэлэн бүтээгдэхүүн	89,861,748.83	84,869,731.66
354	Хангамжийн материал	68,839,445.54	78,212,501.99
35410	Бичиг хэргийн материал	1,290,969.52	1,360,907.52
35420	Аж ахуйн материал	22,318,762.64	32,319,262.64
35430	Сэлбэг хэрэгсэл	3,985,000.00	3,985,000.00
35440	Түлш, шатах тослох материал	5,516,560.00	1,537,087.20
35450	Барилгын засварын материал	14,826,156.66	14,316,156.66
35460	Хүнсний материал	18,512,419.52	19,354,865.60
35470	Бусад хангамжийн материал	2,389,577.20	5,339,222.37
35600	Мал амьтад	17,479,200.00	39,573,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,361,157,657.19	11,268,543,506.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,361,157,657.19	11,268,543,506.46
392	Биет хөрөнгө	2,958,895,657.19	2,866,281,506.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,738,808,476.06	2,807,434,980.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	(236,650,255.27)	(341,613,336.02)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	365,253,875.00	365,253,875.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(212,238,874.43)	(260,192,207.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	515,464,027.90	573,219,626.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(308,529,448.29)	(386,329,160.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,386,347.29	52,020,247.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,321,034.30)	(36,036,648.37)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	28,170,620.00	28,170,620.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,569,000.00	17,252,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,949,344.42)	(7,193,099.88)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	39,932,267.65	54,294,610.00
393	Биет бус хөрөнгө	8,402,262,000.00	8,402,262,000.00
39301	Программ хангамж	6,417,692.31	6,417,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,417,692.31)	(6,417,692.31)

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39303	Бусад биет бус хөрөнгө	8,402,262,000.00	8,402,262,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,625,183,561.71</u>	<u>11,550,690,528.65</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>14,652,714.80</u>	<u>73,516,182.39</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,652,714.80	73,516,182.39
413	Өглөг	14,652,714.80	73,516,182.39
4136	Бусад өглөг	14,652,714.80	73,516,182.39
41361	Байгууллагад төлөх өглөг	-	59,553,054.50
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	14,652,714.80	13,963,127.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,610,530,846.91</u>	<u>11,477,174,346.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	11,610,530,846.91	11,477,174,346.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,727,358,630.01	8,727,358,630.01
51101	Өмч: - төрийн	8,727,358,630.01	8,727,358,630.01
512	Хуримтлагдсан үр дүн	617,925,353.30	484,568,852.65
51210	Өмнөх үеийн үр дүн	786,079,132.84	617,925,353.30
51220	Тайлант үеийн үр дүн	(168,153,779.54)	(133,356,500.65)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,265,246,863.60	2,265,246,863.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,625,183,561.71</u>	<u>11,550,690,528.65</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,533,211,392.00	2,406,913,026.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	473,130,992.00	378,944,088.27
120	Нийтлэг татварын бус орлого	473,130,992.00	378,944,088.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	473,130,992.00	378,944,088.27
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	283,311,503.00	269,890,970.41
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	189,819,489.00	109,053,117.86
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,060,080,400.00	2,027,968,938.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,060,080,400.00	2,003,640,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,060,080,400.00	2,003,640,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	24,328,238.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		24,328,238.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,701,365,171.54	2,540,269,526.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,701,365,171.54	2,540,269,526.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,583,695,670.27	2,446,284,738.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,365,834,058.32	1,363,403,158.73
210101	Үндсэн цалин	829,448,900.00	896,951,695.25
210102	Нэмэгдэл	534,385,158.32	466,451,463.48
210104	Урамшуулал	2,000,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,424,410.41	28,144,101.19
210201	Тэтгэврийн даатгал	1,193,261.68	1,092,958.42
210202	Тэтгэмжийн даатгал	140,383.73	90,266.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	112,306.99	72,213.01
210204	Ажилгүйдлийн даатгал	28,076.72	18,053.23
210205	Эрүүл мэндийн даатгал	26,950,381.29	26,870,610.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,615,690.00	209,377,724.03
210301	Гэрэл, цахилгаан	127,276,432.00	110,515,401.37
210302	Түлш, халаалт	74,198,908.00	80,720,022.66
210303	Цэвэр, бохир ус	43,140,350.00	18,142,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	119,482,742.92	151,267,256.97
210401	Бичиг хэрэг	6,699,943.00	7,614,874.51
210402	Тээвэр, шатахуун	26,505,545.00	28,832,379.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,709,100.00	2,740,109.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	493,600.00	496,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,912,700.00	12,903,650.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	76,521,817.82	93,916,942.87
210408	Бараа материал акталсны зардал	2,640,037.10	4,763,300.00
2105	Нормативт зардал	438,669,334.31	336,478,989.31
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,094,945.97	14,472,419.10
210502	Хоол, хүнс	362,800,140.34	289,495,044.71
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	61,774,248.00	32,511,525.50

**Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй,
хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,479,151.00	52,585,781.73
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,842,031.00	11,137,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,178,570.00	156,500.00
210604	Урсгал засвар	28,458,550.00	41,291,681.73
2107	Томилолт, зочны зардал	2,209,400.00	731,800.00
210702	Дотоод албан томилолт	2,209,400.00	731,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,686,527.85	20,636,190.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,305,213.85	13,319,690.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	935,768.00	936,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	466,000.00	533,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,107,998.00	1,108,000.00
210807	Газрын төлбөр	4,271,548.00	4,738,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	277,294,355.46	283,659,736.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,078,545.97	46,780,740.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,393,910.00	1,203,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	233,821,899.49	235,675,496.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,669,501.27	93,984,788.31
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	29,357,600.00	23,167,200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	29,357,600.00	23,167,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,246,784.00	10,567,498.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,246,784.00	10,567,498.40
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,117.27	235,210.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,117.27	235,210.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,000,000.00	60,014,879.91
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,000,000.00	60,014,879.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(168,153,779.54)	(133,356,500.65)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(168,153,779.54)	(133,356,500.65)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,436,103,013.38	2,501,615,010.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	376,087,730.65	383,899,347.04
120	Нийтлэг татварын бус орлого	376,087,730.65	383,899,347.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	376,087,730.65	367,275,004.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	376,087,730.65	367,275,004.51
120009	Бусад орлого	-	16,624,342.53
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,060,015,282.73	2,117,715,663.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,060,015,282.73	2,003,405,490.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,060,015,282.73	2,003,405,490.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	114,310,173.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	109,261,173.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,049,000.00
131106	Төсвийн урамшуулал		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,447,503,595.47	2,499,325,756.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,447,503,595.47	2,499,325,756.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,330,029,495.47	2,380,768,596.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,365,834,058.32	1,379,731,722.43
210101	Үндсэн цалин	829,448,900.00	903,045,884.64
210102	Нэмэгдэл	534,385,158.32	476,685,837.79
210104	Урамшуулал	2,000,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,424,410.41	28,339,880.02
210201	Тэтгэврийн даатгал	1,193,261.68	1,191,281.92
210202	Тэтгэмжийн даатгал	140,383.73	105,191.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	112,306.99	71,033.11
210204	Ажилгүйдлийн даатгал	28,076.72	17,758.25
210205	Эрүүл мэндийн даатгал	26,950,381.29	26,954,615.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	246,702,000.00	211,733,500.00
210301	Гэрэл, цахилгаан	130,954,182.00	111,892,643.74
210302	Түлш, халаалт	72,607,468.00	81,698,556.26
210303	Цэвэр, бохир ус	43,140,350.00	18,142,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	78,023,500.00	83,641,073.00
210401	Бичиг хэрэг	5,107,200.00	4,512,840.01
210402	Тээвэр, шатахуун	67,584,400.00	64,283,438.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,709,100.00	2,740,109.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	493,600.00	496,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,129,200.00	11,608,685.00
2105	Нормативт зардал	321,476,500.00	291,029,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,834,300.00	13,369,400.00
210502	Хоол, хүнс	309,642,200.00	277,660,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,446,000.00	144,632,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,621,200.00	74,487,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,049,300.00	2,049,300.00
210604	Урсгал засвар	28,775,500.00	68,096,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,209,400.00	731,800.00

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	2,209,400.00	731,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	185,862,826.74	133,052,611.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	178,481,512.74	125,736,111.01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	935,768.00	936,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	466,000.00	533,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,107,998.00	1,108,000.00
210807	Газрын төлбөр	4,271,548.00	4,738,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,050,800.00	107,875,910.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,657,100.00	106,668,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,393,700.00	1,207,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,474,100.00	118,557,160.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	29,357,600.00	23,167,200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	29,357,600.00	23,167,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,116,500.00	9,895,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,116,500.00	9,895,200.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,000,000.00	85,494,760.41
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,000,000.00	85,494,760.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(11,400,582.09)</u>	<u>2,289,253.17</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(11,400,582.09)	2,289,253.17
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,053,296.89	14,652,714.80
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,652,714.80	16,941,967.97

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,102,068,630.0	2,265,246,863.6	786,079,132.8	4317143998 7,153,394,626.4
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,102,068,630.0	2,265,246,863.6	786,079,132.8	7,153,394,626.4
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн			(168,153,779.5)	(168,153,779.5)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,102,068,630.0	2,265,246,863.6	617,925,353.3	6,985,240,846.9
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,102,068,630.0	2,265,246,863.6	449,771,573.8	6,985,240,846.9
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,102,068,630.0	2,265,246,863.6	617,925,353.3	6,985,240,846.9
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			(133,356,500.6)	(133,356,500.6)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,102,068,630.0	2,265,246,863.6	484,568,852.6	6,851,884,346.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,188,690,700.0	2,188,455,500.0	235,200.0	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,188,690,700.0	2,188,455,500.0	235,200.0	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	760,967,000.0	760,967,000.0	431,143,998	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,375,266,800.0	1,375,266,800.0	МНОА00055 00554100	100.0
210101	Үндсэн цалин	853,247,700.0	902,725,884.6	(49,478,184.6)	105.8
210102	Нэмэгдэл	517,075,100.0	472,540,915.4	44,534,184.6	91.4
210104	Урамшуулал	4,944,000.0	-	4,944,000.0	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,109,300.0	28,109,300.0	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	-	977,101.9	(977,101.9)	-
210202	Тэтгэмжийн даатгал	-	88,791.4	(88,791.4)	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	71,033.1	(71,033.1)	-
210204	Ажилгүйдлийн даатгал	-	17,758.3	(17,758.3)	-
210205	Эрүүл мэндийн даатгал	28,109,300.0	26,954,615.4	1,154,684.6	95.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	211,733,500.0	211,733,500.0	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	114,517,400.0	111,892,643.7	2,624,756.3	97.7
210302	Түлш, халаалт	75,397,700.0	81,698,556.3	(6,300,856.3)	108.4
210303	Цэвэр, бохир ус	21,818,400.0	18,142,300.0	3,676,100.0	83.2
2104	Хангамж, бараа материалын зардал	70,422,700.0	70,422,700.0	-	100.0
210401	Бичиг хэрэг	2,426,700.0	3,744,590.0	(1,317,890.0)	154.3
210402	Тээвэр, шатахуун	60,740,100.0	52,766,250.0	7,973,850.0	86.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,347,900.0	2,740,110.0	(392,210.0)	116.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	444,100.0	496,000.0	(51,900.0)	111.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,463,900.0	10,675,750.0	(6,211,850.0)	239.2
2105	Нормативт зардал	291,029,800.0	291,029,800.0	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,369,400.0	13,369,400.0	-	100.0
210502	Хоол, хүнс	277,660,400.0	277,660,400.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91,832,300.0	91,832,300.0	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	53,687,000.0	53,687,000.0	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,049,300.0	2,049,300.0	-	100.0
210604	Урсгал засвар	36,096,000.0	36,096,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	500,000.0	500,000.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	500,000.0	500,000.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,859,500.0	24,859,500.0	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,543,000.0	17,543,000.0	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	936,900.0	936,900.0	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	533,000.0	533,000.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,108,000.0	1,108,000.0	-	100.0
210807	Газрын төлбөр	4,738,600.0	4,738,600.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,589,200.0	70,589,200.0	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,381,400.0	69,381,400.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,207,800.0	1,207,800.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,347,600.0	24,112,400.0	235,200.0	99.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	23,402,400.0	23,167,200.0	235,200.0	99.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	23,402,400.0	23,167,200.0	235,200.0	99.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	945,200.0	945,200.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	945,200.0	945,200.0	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,188,690,700.0	2,188,455,500.0	235,200.0	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,003,640,700.0	2,003,875,910.0	(235,210.0)	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,003,640,700.0	2,003,875,910.0	(235,210.0)	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	185,050,000.0	185,050,010.0	(10.0)	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	185,050,000.0	185,050,010.0	(10.0)	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	114,310,173.0
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	114,310,173.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	114,310,173.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	114,310,173.0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,218,373.0
210401	Бичиг хэрэг	768,250.0
210402	Тээвэр, шатахуун	11,517,188.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	932,935.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,800,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,800,000.0
210604	Урсгал засвар	32,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	231,800.0
210702	Дотоод албан томилолт	231,800.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,773,290.0
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,773,290.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,286,710.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,286,710.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	114,310,173.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	114,310,173.0
131104	Нэмэлт санхүүжилтийн орлого	114,310,173.0

2.7 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Ахмадын сан/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,645,502.45
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	13,645,502.45
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,695,502.45
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл суутгал	4,464,922.43
210101	Үндсэн цалин	320,000.0
210102	Нэмэгдэл цалин	4,144,922.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,580.02
210201	Тэтгэврийн даатгал	214,180.0
210202	Тэтгэмжийн даатгал	16,400.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,950,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,950,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,950,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	16,624,342.53
300001	Нэр данс зөрүүтэй орлого	100,000.0
1200042	Үндсэн бус үйл ажиллагааны бусад орлого	16,524,342.53
3101	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	2,978,840.08

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн /Цаашид Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих анги гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн цахим төлбөрийн баримт, анхан шатны баримтын бүрдэл, бараа материалыг зөв ангилан бүртгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих анги нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 42/3-91 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих ангийн эрхэм зорилго нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлж, албаны бэлэн байдал, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх”-д оршино.

Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих ангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэн, ашиглалтыг эрчимжүүлэх,
- Байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах ажлыг шат дараатай хэрэгжүүлэх,
- Шударга ёс, ил тод байдлыг хангаж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүндрэлгүй зохион байгуулах,
- Нийт бие бүрэлдэхүүнтэй цэрэгжилт, албаны бэлэн байдал, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс болон шууд захирагчийн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,701,365.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 27,013.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 18,909.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих ангийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,688.8 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14,652.7	16,941.2	2,288.5
Авлага	7,143.5	7,000.0	(143.5)
Урьдчилгаа			
Бараа материал	242,229.7	258,246.6	16,016.9
Үндсэн хөрөнгө	11,361,157.7	11,268,306.3	(92,851.4)
Нийт хөрөнгө	11,625,183.6	11,550,494.8	(74,688.8)
Өр төлбөр	14,652.7	73,559.0	58,906.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,610,530.8	11,476,935.9	(133,594.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,625,183.6	11,550,494.8	(74,688.8)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 16,941.2 мянган төгрөг болж өмнөх оноос 2,288.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд хоригдлын нэрийн дансанд байршиж байгаа цалин, ар гэрээс шилжүүлсэн мөнгөний үлдэгдлээс шалтгаалжээ.

Авлагын дансны үлдэгдэл 7,000.0 мянган төгрөг болж 143.5 мянган төгрөгөөр буурсан нь ШШГЕГ-аас салбар хоорондын авлага 7,143.5 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж, БИММ ХХК-гаар “Өрөмдлөгийн ажил гүйцэтгүүлэх” 12,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, ажлын урьдчилгаа 7,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 258,246.6 мянган төгрөг болж 16,016.9 мянган төгрөгөөр өссөн нь ШШГЕГ-аас 65,345.2 мянган төгрөгийн материалыг шилжүүлэн авсан болон төсвийн хөрөнгөөр 670,157.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 771,387.0 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсан, 31,965.0 мянган төгрөгийн материалыг салбар хооронд шилжүүлсэн, 4,734.3 мянган төгрөгийн материалыг акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 12,299,908.0 мянган төгрөг болж өмнөх оноос 143,061.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 54,368.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан болон ШШГЕГ-аас 5,704.0 мянган төгрөгийн тоног, төхөөрөмж, аймгийн ОНХС-ийн

хөрөнгөөр хэрэгжүүлсэн 28,694.2 мянган төгрөгийн 1 айлын орон сууцны барилга зэргийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, 54,294.6 мянган төгрөгийн өвлийн хүлэмж барих ажлыг дуусаагүй барилга байгууламжаар бүртгэсэн зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 73,559.0 мянган төгрөг болж 58,906.3 мянган төгрөгөөр өссөн нь ШШГЕГ-т төслийн зээлийн эргэн төлөлтийн 59,495.8 мянган төгрөг, нэр данс зөрүү 100.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, хоригдлын нэрийн дансанд байршиж байгаа цалин, ар гэрээс илгээсэн мөнгөний үлдэгдэл 689.5 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,476,935.9 мянган төгрөг болж, 133,594.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 126,300.1 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар буурсан нь тусламж санхүүжилтийн орлого болон өөрийн орлого буурснаас шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 160,858.9 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан нь нормативт зардал, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал буурснаас голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг тус бүр 2,572,046.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 383,356.2 мянган төгрөгөөр бууруулж, 2,188,690.7 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хоол хүнсний зардлыг 157,749.4 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 43,992.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийг 8,941.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталснаас голлон шалтгаалсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр **2,188,690.7** мянган төгрөгийн төсөв баталснаас 2,003,640.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 185,050.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,003,640.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 270,544.8 мянган төгрөг, нийт 2,274,185.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **2,188,455.5** мянган

төгрөгийг зарцуулан, давсан орлогоос дээд шатны төсвийн захирагчид 60,014.9 мянган төгрөг, төслийн эргэн төлөлтөд 25,479.9 мянган төгрөгийг тус тус шилжүүлэн, төсвийн хэмнэлт 235.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,188,455.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

ШШГЕГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/11 дүгээр тушаалын дагуу төрийн санд 100130412507 тоот "Ахмадын сан"-ийн данс нээж цалингийн зардлаас 16,524.3 мянган төгрөгийг шилжүүлэн, нэр данс зөрүүтэй 100.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэж нийт 16,624.3 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна. Үүнээс ахмадын зөвлөлийн даргын цалинд 4,695.5 мянган төгрөг, нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардалд 8,950.0 мянган төгрөгийг тус тус зарцуулан, тайлант оны эцэст 2,978.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ШШГЕГ-аас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан өвлийн хүлэмж, үхрийн фермерийн төслийг хэрэгжүүлэх эргэн төлөгдөх зээлд 84,932.9 мянган төгрөг, шагнал, урамшууллын зардалд 10,800.0 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд 3,528.3 мянган төгрөг, урсгал засварын зардалд 10,000.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5,049.0 мянган төгрөг зэрэг нийт 114,310.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулан ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-аар төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох асуудлыг зохицуулсан байдаг.

Гэтэл албан хаагчдын ажлын үр дүнг дээрх журмын дагуу үнэлж, дүгнэлгүйгээр тус ангийн даргын 2021 оны Б/61 дүгээр тушаалаар албан хаагчдад 10-40 хувиар тооцож нийт 9,151.2 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгохоор / илүү цагийн хөлсийг хувиар бус илүү ажилласан цагт үндэслэн олгохоор зохицуулагдсан байдаг / шийдвэрлэсэн байна. Цаашид илүү цагийн хөлс болон улирлын ажлын үр дүнгийн

мөнгөн урамшууллыг холбогдох хууль, эрхийн актын дагуу үнэн зөв олгохоор шийдвэрлэж байх нь зүйтэй.

3.7.2. ШШГЕГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/11 дүгээр тушаалын дагуу төрийн санд 100130412507 тоот “Ахмадын сан”-ийн данс нээж цалингийн зардлаас тухайн жилийн төсөвт тусгагдаагүй 16,524.3 мянган төгрөгийг шилжүүлсэн байгаа нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах **хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана**” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд дээрх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгуулж батлуулсны үндсэн дээр санхүүжүүлэх шаардлагатай байна.

3.7.3 Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” болсон 304,634.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 154 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа учир цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих анги нь мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс дараах 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан,
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ,

- *Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан*

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн биелүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	9,644.5	1	9,644.5	100
Зөвлөмж	5	-	5	-	100
Нийт дүн	6	9,644.5	6	9,644.5	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 156,726.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5,951.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 150,775.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өгсөн.

4.1 Албан шаардлага:

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй гэх үндэслэлээр ажил олгогчийн шийдвэргүйгээр 27 албан хаагчид 5,951.1 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1-д “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож, биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг... ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна” гэж заасантай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтыг биеэр нөхөн эдлүүлэх, зайлшгүй тохиолдолд ажил олгогчийн шийдвэрийн дагуу цалин, урамшууллыг холбогдох хувь, хэмжээгээр тооцон олгох, давхардуулан олгосон цалинг суутган тооцох албан шаардлага хүргүүлэх.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1 Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1.1. Илрүүлэлт: Газар тариалангийн үйлдвэрлэлийн нөөцөд байгаа 8.0 тонн буюу 8,566.8 мянган төгрөгийн улаан буудайн үрийг бараа материалын тайланд бэлэн бүтээгдэхүүнээр бус малын тэжээл гэж ангилал буруу бүртгэсэн байна.

1.1.2. Өгсөн зөвлөмж: Энэ нь УСНББОУС 12 “Бараа материал”-ын 11-д “...тухайн байгууллагын бараа материалд дуусаагүй үйлдвэрлэл буюу үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүн орно” гэж заасантай нийцээгүй ба “Толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид бараа материалыг данс бүртгэлд зөв ангилан бүртгэх.

1.2 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.2.1. Илрүүлэлт: Тайлант онд 142,208.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2.2. Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	3	156,726.4	-	-	-	-	1	5,951.1	2	150,775.3